

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Галт сумын ТТЗ-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/007/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Ц.Чагнаадорж

Утас: 99387994 Цахим хаяг:
chagnaadorjts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 1/340
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ГАЛТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.ДОЛЖИНЖАВ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Галт сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Галт сумын ТТЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгө нийт 569.0 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогоос 27.4 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос 10.1 сая төгрөгийн орлого тасарсан, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон 13 зээлдэгчтэй холбоотой 87.4 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Галт сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 7 зорилтын 146 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 95.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6725022229

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		669,407.8	1,600,625.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	385,083.7	1,144,054.1
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	160,095.8	231,805.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	123,648.3	224,185.9
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	580.0	580.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,844,148.6	5,195,505.2
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	163,293.9	196,758.2
37300	Урт хугацаат зээл		163,293.9	196,758.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,680,854.7	4,998,747.0
39200	Биет хөрөнгө		4,531,758.3	4,851,936.6
39300	Биет бус хөрөнгө	13	149,096.4	146,810.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		5,513,556.4	6,796,130.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		22,162.2	21,015.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	22,162.2	21,015.5
41300	Өглөг	17а, 17б	22,162.2	21,015.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		5,491,394.2	6,775,114.9
51	Засгийн газрын хувь оролцоо		5,491,394.2	6,775,114.9
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,227,591.4	1,227,591.4
51200	Хуримтлагдсан үр дүн		2,814,427.9	4,106,244.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,449,374.8	1,441,278.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		5,513,556.4	6,796,130.4

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,095,210.4	3,631,050.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО		759,511.6	1,946,128.5
110	Орлогын албан татвар		380,590.5	856,729.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		409,078.9	856,729.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-28,488.5	0.0
113	Хөрөнгийн албан татвар		74,522.8	73,474.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж		304,398.4	1,015,924.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	182,677.2	364,302.7
120	Нийтлэг татварын бус орлого		179,377.2	364,302.7
121	Хөрөнгийн орлого		3,300.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,153,021.5	1,320,619.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,771,427.1	2,322,342.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,771,427.1	2,322,342.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,596,673.0	2,212,987.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		519,860.3	846,352.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		67,106.8	105,793.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		36,756.3	430,752.9
2104	Хангамж, бараа материалын зардал		92,393.5	89,202.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		33,897.2	89,547.0
2107	Томилолт, зочны зардал		8,594.2	7,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		503,362.8	123,161.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		334,701.9	520,577.0

Хөвсгөл аймгийн Галт сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		174,754.2	109,355.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		323,783.2	1,308,708.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		7,526.9	24,988.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		316,256.4	1,283,720.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,025,321.0	3,278,908.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	759,511.6	1,877,535.4
110	Орлогын албан татвар	380,590.5	856,729.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	409,078.9	856,729.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-28,488.5	0.0
113	Хөрөнгийн албан татвар	74,522.8	73,474.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	304,398.4	947,331.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	29,618.4	38,424.5
1181	Газрын төлбөр	7,301.7	24,253.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	267,478.3	884,653.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,787.9	80,753.3
120	Нийтлэг татварын бус орлого	109,487.9	80,753.3
121	Хөрөнгийн орлого	3,300.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,153,021.5	1,320,619.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,987,819.5	2,007,784.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,987,819.5	2,007,784.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,328,476.6	1,965,726.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,775.8	848,409.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,106.8	103,736.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,916.3	430,392.9
2104	Хангамж, бараа материалын зардал	57,818.2	81,207.3
2105	Нормативт зардал	1,000.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,689.5	88,449.0
2107	Томилолт, зочны зардал	8,594.2	7,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	514,141.6	110,245.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,434.3	295,685.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	659,343.0	42,057.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	37,501.5	1,271,124.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	32,260.5	423,153.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,260.5	423,153.7
2200	Дотоод эх үүсвэрээр	32,260.5	423,153.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-32,260.5	-423,153.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-75,000.0	-89,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	75,000.0	89,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-69,759.0	758,970.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	454,842.7	385,083.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	385,083.7	1,144,054.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хөвсгөл аймгийн Галт сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,175,137.8	5,175,137.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	316.3	316.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,175,454.2	5,175,454.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-316.3	-316.3
9	Тайлант үеийн үр дүн	316,256.4	316,256.4
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,491,394.2	5,491,394.2
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,491,394.2	5,491,394.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,096.0	8,096.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,499,490.2	5,499,490.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-8,096.0	-8,096.0
19	Тайлант үеийн үр дүн	1,215,127.6	1,215,127.6
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,706,521.8	6,706,521.8

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,506,183.90	2,381,515.18	124,668.72	95.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,961,009.50	1,899,386.46	61,623.04	96.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,950,569.90	1,888,964.36	61,605.54	96.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	850,133.80	842,303.93	7,829.87	99.08
210101	Үндсэн цалин	480,253.20	468,187.12	12,066.08	97.49
210102	Нэмэгдэл	267,954.40	280,622.82	-12,668.42	104.73
210104	Урамшуулал	86,650.20	78,217.99	8,432.21	110.78
210105	Гэрээт ажлын хөлс	15,276.00	15,276.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,266.70	103,736.64	2,530.07	102.44
210201	Тэтгэврийн даатгал	72,261.40	70,216.84	2,044.56	102.91
210202	Тэтгэмжийн даатгал	8,501.40	8,380.20	121.20	101.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,434.10	7,336.60	97.50	101.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,858.50	1,833.90	24.60	101.34
210205	Эрүүл мэндийн даатгал	16,211.30	15,969.10	242.20	101.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	461,454.40	427,577.62	33,876.78	107.92
210301	Гэрэл, цахилгаан	65,741.00	60,768.45	4,972.55	108.18
210302	Түлш, халаалт	384,800.30	360,896.36	23,903.94	106.62
210303	Цэвэр, бохир ус	10,913.10	5,912.80	5,000.30	184.57
2104	Хангамж, бараа материалын зардал	76,342.00	75,907.40	434.60	100.57
210401	Бичиг хэрэг	8,177.00	8,177.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	44,700.00	44,700.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,000.00	4,798.20	201.80	104.21
210404	Ном, хэвлэл	2,875.00	2,643.00	232.00	108.78
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,700.00	2,700.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,890.00	12,889.20	0.80	100.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	116,105.00	113,105.00	3,000.00	102.65

Хөвсгөл аймгийн Галт сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	29,885.00	29,885.00	0.00	100.00
210602	Тавилга	14,270.00	14,270.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	71,950.00	68,950.00	3,000.00	104.35
2107	Томилолт, зочны зардал	7,600.00	7,600.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	7,600.00	7,600.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,011.50	82,011.88	11,999.62	114.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,011.50	79,298.30	11,713.20	114.77
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,200.00	2,119.20	80.80	103.81
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200.00	0.00	200.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100.00	100.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	500.00	494.38	5.62	101.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	238,656.50	236,721.90	1,934.61	100.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	225,546.50	225,454.90	91.61	100.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,110.00	11,267.00	1,843.00	116.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,439.60	10,422.10	17.50	100.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,439.60	10,422.10	17.50	100.17
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,439.60	10,422.10	17.50	100.17
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	455,924.40	393,128.72	62,795.68	115.97
223001	Бусад хөрөнгө	455,924.40	393,128.72	62,795.68	115.97
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	89,250.00	89,000.00	250.00	100.28
230001	Эргэж төлөгдөх зээл	89,250.00	89,000.00	250.00	100.28
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,506,183.90	2,384,489.70	121,694.20	105.10
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	306,314.40	0.00	306,314.40	0.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	306,314.40	0.00	306,314.40	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,682,149.40	2,305,889.38	-623,739.98	72.95
320001	Орон нутгийн төсвөөс	1,682,149.40	1,999,574.98	-317,425.58	84.13
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	517,720.10	78,600.32	439,119.78	658.67
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	86,750.00	70,707.91	16,042.09	122.69
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,500.00	7,892.41	607.59	107.70
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	422,470.10	0.00	422,470.10	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.06	0.06	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	0.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	0.00	0.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.03	0.03	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	0.00	0.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	0.02	0.02	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	0.01	0.01	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.03	0.03	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	0.01	0.01	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	0.01	0.01	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	0.01	0.01	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Хөвсгөл аймгийн Галт сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	138,422.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,422.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,787.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,105.4
210105	Гэрээт ажлын хөлс	6,105.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,815.2
210301	Гэрэл, цахилгаан	2,815.2
2104	Хангамж, бараа материалын зардал	5,299.8
210401	Бичиг хэрэг	350.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,949.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	639.0
210604	Урсгал засвар	639.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,963.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,963.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,964.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,964.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,635.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,635.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,635.3
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	138,422.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,422.7
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,784.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,779.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,859.5

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 3 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 125.1 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Галт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 9.3 сая төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж хүргүүлсэн байна.

Галт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 9.3 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн болно.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй 13 зээлдэгчийн нийт 87.5 сая төгрөгийн зээлийг барагдуулаагүй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах

2. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 2 нэр төлийн нийт 27.4 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын дотоод бараа үйлчилгээний НӨАТ-ийн орлого 5.2 сая төгрөг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 4.9 сая төгрөгөөр нийт 37.5 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь гүйцэтгэлийг хангаж ажиллах

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны цахим хуудсанд нийт 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4.1 хэсэгтэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Илрүүлэлт: Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийхэд дараах зөрчил илэрсэн.

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл
- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгүүлсэн арга хэмжээний тайлан

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь ил тод мэдээлж ажиллах

4. Богино хугацаат өр төлбөрийн талаар

Илрүүлэлт: 2020 оны жилийн эцсээр сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 0.1 сая төгрөгийг сумын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлж, байгууллагад өгөх өглөгөөр тусгаж 4 жил болсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1, төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4.3.12 заалтын дагуу орон нутгийн 100170500910 тоот дансанд төвлөрүүлэх.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8 төсвийг зохистой удирдаж авлага, өр үүсгэхгүй ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5."Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс																				
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал												
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн									

Хөвсгөл аймгийн Галт сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	87.5					1	87.5				
Өр төлбөр	1	0.1					1	0.1				
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	37.5					1	37.5				
Дүн	3	125.1					3	125.1				
Харьяа байгууллагуудын зөрчил /ЗДТГ/												
Балансын урамшуулал	1	3.9					1	3.9				
Авлага барагдуулах	1	5.4					1	5.4				
Дүн	2	9.3					2	9.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны мэдээлэл	1						1					
Дүн	1						1					
Харьяа байгууллагуудын зөрчил /ЗДТГ/												
Ахмадын сан	1	-					1	-				
Дүн	1						1					